

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№ 16/438

ШУС, НУС

2015

ОЛОН НИЙТИЙН СЭТГҮҮЛ ЗҮЙН СУРГАЛТЫН
ОНОЛ, ПРАКТИКИЙН ЗАРИМ АСУУДАЛ

Н.Ариунзаяа*, П.Цэрэнням**

* “Отгонтэнгэр” Их сургуулийн Сэтгүүл зүйн тэнхимийн багш, сэтгүүл зүйн доктор (Ph.D)

** МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Нийгмийн ухааны салбарын Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн докторант, сэтгүүл зүйн магистр

Түлхүүр үг: стандарт сэтгүүл зүй, хувийн хэвлэл, олон нийт, бүтэц, Харвүүд бүлэг, шинжилгээ, зорилго, философи, эерэг нөлөө, олон нийтийн хэлэлцүүлэг

Ерээд оны эхээр Монгол оронд өрнөсөн ардчилсан хувьсгал манай орны нийгэм, улс төр, эдийн засгийн амьдрал, оюуны салбарын бүхий л хүрээ, түүний дотор сэтгүүл зүйн үйл ажиллагаанд эргэлтийн шинжтэй өөрчлөлт гаргасан билээ. Энэ өөрчлөлтийн явцад мэдээллийн уламжлалт хэрэгслүүд хүрээгээ тэлж, сэтгүүл зүйн урьд өмнө сонсогдож байгаагүй шинэ хэлбэрүүдийн тухай ярьж, бичих болсон. Үүний нэг нь олон нийтийн сэтгүүл зүй юм.

Сэтгүүл зүйн энэ шинэ чиглэлийн ирээдүйг зөгнөж Америкийн судлаач Женни Бакнер «Хэзээ та иргэдтэй харилцаж эхэлнэ, тэд таныг сэтгүүл зүйд цэцэн мэргэнээр газарчилж өгнө»¹ гэж оновчтой хэлсэн байдаг. Олон нийтийн сэтгүүл зүй нь нэг талаас хэвлэл мэдээллийн хэрэгслээс амьдралын гүн лүү тавих анхаарлаа нэмэгдүүлж, жирийн иргэдийн ахуй

амьдралыг илүү тусгах үйл ажиллагаа, нөгөө талаас хэвлэл мэдээллийн үйл ажиллагаанд иргэдийг өргөнөөр татан оролцуулж тэднээс ахуй амьдралынхаа тулгамдсан асуудлыг сөхөн тавьж, шийдвэрлэхэд нь мэдээллийн хэрэгсэл, сэтгүүлчид туслах явдал юм. Энэ утгаараа мэргэжлийн сэтгүүл зүй, олон нийтийн сэтгүүл зүй хоёрын зохистой хослол буй болж бие биеэ нөхөн хөгжиж байна.

Монголын сэтгүүл зүйн шинэ чиглэлийн нэг болох «Олон нийтийн сэтгүүл зүй нь юуны өмнө амьдралдаа тохиолдсон чухал асуудлыг мэдээлэхэд идэвхтэй оролцдог сонгогчдын сэтгүүл зүйн үйл ажиллагаа юм»² гэж судлаачид тодорхойлсон байна. Олон нийтийн хэвлэлүүд, ялангуяа нийтлэлийн бодлогоороо олон нийттэй хүчтэй холбогддог сонинуудын үйл ажиллагаанд нийгмийн идэвхтэй хэсэг түлхүү оролцож, иргэний чухал асуудлыг мэдээлэх болсноор олон нийтийн сэтгүүл зүй үүссэн байна. Олон нийтийн сэтгүүл зүй нь интерактив сэтгүүл зүйн нэг хэлбэр бөгөөд амьдралын өөр өөр түвшний хүмүүсийг сонин сэтгүүлд өгүүлэл материал

бичүүлэх, амьдралаас олж илрүүлсэн зүйлээ мэдээлэхэд өргөнөөр татан оролцуулдаг сэтгүүл зүйн үйл ажиллагаа юм.

Америкийн сэтгүүлч эрдэмтэд олон нийтийн сэтгүүл зүйн нийгэмд гүйцэтгэх үүргийг олонтаа тодорхойлсны дотор эрдэмтэн Гунаратне сэтгүүл зүйн энэ хэлбэрийн өөр өөр шинж чанарыг илтгэсэн гурван янзын тодорхойлолт гаргасан байна. Тэрбээр *нэгдүгээрт*: энгийн иргэдийн дотроос идэвхтэй хэсгийг нэгтгэх замаар олон нийтийн ухамсарт хүч нэмж, зоригжуулахад сэтгүүл зүйг чиглүүлэх хөдөлгөөн мөн гэжээ. Энэ нь олон нийтийн сэтгүүл зүй олон талтай болохыг харуулж байгаа юм. *Хоёрдугаарт*: олон нийтийн анхаарал татсан асуудлыг хэлэлцэхэд өөрийн ухамсраар оролцож дуу хоолойгоо илэрхийлэх идэвх бүхий олон нийтийг буй болгох хөдөлгөөн хэмээн тодорхойлжээ. *Гуравдугаарт*: нэг талаас хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан мэдээлэл түгээх үйл явцыг илүү эрчимтэй болгон олон нийтэд хүрч ажиллах, нөгөө талаас иргэд тулгарсан асуудлууддаа хэрхэн хандаж байгаа хийгээд түүнийг шийдвэрлэх арга замыг хэрхэн эрж хайж байгааг тодорхойлох оролдлого³ гэсэн байна.

Өнөөдөр олон нийтийн сэтгүүл зүй нь сэтгүүл зүйн шинэ чиглэл төдий байхаа аль хэдийнээ больж, харин түүний сургалтын асуудал анхаарал татах болжээ. Ийнхүү стандарт сэтгүүл зүйн агуулгыг баяжуулах зорилгоор “Олон нийтийн сэтгүүл зүй” хэмээх нэр томъёо орж ирснийг сэтгүүл зүйн академичлал хэмээн тодорхойлж болох юм. Өнгөрсөн зууны далаад он хүртэл их сургуулийн мэргэжлийн сэтгүүл зүйн нөлөө тогтвортой өсч байлаа. Өөрөөр хэлбэл их сургуулийн

боловсрол л хэвлэл мэдээллийн салбарт ямар ч өрсөлдөгчгүйгээр үүрэг хүлээдэг байв. АНУ-ын 1930-аад оны сонгодог кино болох «Эхний нүүр» кинонд нэгэн их сургуулийн оюутан залууг гэнэн итгэмтгий, эмэгтэйлэг, сэтгүүл зүйн өдөр тутмын хатуу шаардлагад дасан зохицох чадваргүй мэтээр дүрслэн харуулсан байдаг.

Т авиад онд гарсан «Багшийн тэжээвэр амьтан» гэдэг кинонд мөн л их сургуулийн сэтгүүл зүйг утгагүй, хэрэгцээгүй зүйл гэж үздэг их зантай, хамраа сөхсөн редактор, тийм санаа бодолтой сэтгүүлчдийн үл тоомсорлосон байдлыг илчилж байв. «Багшийн тэжээвэр амьтан» кинонд ууртай, гэжүүд зантай редакторын дүрийг бүтээсэн Кларк Кэйбли «Их сургуулийн сургалтад суурилсан стандарт сэтгүүл зүй нь мэргэжлийн бус сэтгүүл зүй юм. Зөвхөн сайн дурын хүмүүс л ийм зүйлийг заадаг»⁴ гэж эрс шүүмжилжээ. Энэ үгийн цаад утга нь сэтгүүл зүй заадаг хүн зөвхөн мэргэжлийн онолд найдаж, түүнийг амьдралаас хөндий номлох биш, сэтгүүлчийн хар бор ажилд оюутныг гаршуулж мэргэшүүлэх туршлагатай байх ёстой гэсэн санаа байх. Кэйблийг тэгэж хэлснээс хойш дөчөөд жилийн дараа сэтгүүл зүйг олон нийтийн шинжтэй болгох үйлсэд эерэг нөлөөллүүд гарч эхэлсэн. Гэсэн хэдий ч олон нийтийн сэтгүүл зүйд мэргэжлийн зааварчилгааг маш их оруулсаар байсан нь хэрэв савлуур хэтэрхий хол савлаад байвал аюултайн нэгэн адил үр ашиг нь багасах вий гэсэн айдсыг мэргэжлийн ажиглагчдад төрүүлсэн юм.

Олон нийтийн сэтгүүл зүй хэмээх мэргэжлийн нэр томъёог Нью-Йоркийн Их сургуулийн профессор, энэ салбарын оюун санааны удирдагч Розен

сайшаан магтсан байдаг. Тэрээр Буффало дахь Нью-Йоркийн Их сургуулийн сонины редактор, дараа нь «Buffalo Courier Express»-ийн сэтгүүлчээр ажиллаж байсан туршлагатай сэтгүүлч юм. Түүнийг сэтгүүл зүйд ажиллахыг хязгаарласан учраас сургуулийн болон хотын зөвлөлөөс гарч, улмаар «Courier Express»-ийг орхисон байна. Тэрээр Нью-Йоркийн Их сургуулийн хэвлэлийн тэнхимд экологийн сэтгүүл зүйн магистрт сурахаар санаа шулууджээ. Розен Жон Деви, Волтер Липман нарын сэтгүүл зүйн талаарх маргааны судалгаагаар магистрын ажлаа амжилттай хамгаалсны дараа Нью-Йоркийн Их сургуулийн Сэтгүүл зүйн салбарт ажиллах болжээ.

Розен олон нийтийн сэтгүүл зүйг онолын болон академик талаас нь судлахад оруулсан хувь нэмрээ тодорхойлж хэлэхдээ «Би энэ хөдөлгөөний явцад шинээр гарч байгаа сонинд шинэ үгсийн сан, нэр томьёо тогтоож хэвшүүлэх үүрэгтэй оролцсон» гэсэн байдаг. Тэрээр энэ зорилтоо олон нийтийн сэтгүүл зүйн туршлагатай редакторууд болон бодлого судлаач эрдэмтэд, зөвлөгөө өгөх фирмүүдтэй хамтран ажиллаж хэвлэл мэдээллийн шинэ чиглэлийн нэр томьёог боловсруулсан байна.

Олон нийтийн сэтгүүл зүйн нэр томьёог ойлгох хамгийн сайн номуудын нэг нь 1955 онд хэвлэгдсэн Артур Чаритигийн «Олон нийтийн сэтгүүл зүй» гэдэг бүтээл юм. Чарити Нью-Йоркийн Их сургуульд Розений эрхэлж байсан хувийн хэвлэлийн газарт сэтгүүл зүйн арга туршлагын шинэ санаануудыг нэгтгэн зангидах чиглэлээр ажилладаг байсан бөгөөд уг ном нь тэнд хийсэн судалгааных нь үр дүн аж.

Олон нийтийн сэтгүүл зүйг хөгжүүлэхэд дор дурдсан үг хэллэг, нэр

томьёог дав даруй хэвшүүлэх хэрэгтэй гэж тэрээр үзжээ. Үүнд:

Олон нийтийн үлбэгэр байдал. Энэ нь тухайн нийгэмд иргэд нь улс төрийн амьдралаас хол хөндий байж, ямар нэг өөрчлөлт хийхэд оролцохоос зайлсхийдэг идэвхгүй байдлыг тэмдэглэсэн ойлголт юм. Ийм нийгэмд иргэдийн оролцоо туйлын хангалтгүй байдаг. Энэ нь сэтгүүлчдэд аюултай бөгөөд Розений хэлснээр «Хэрэв нийгмийн амьдрал чухал биш болвол сэтгүүл зүй ч байхгүй болно» хэмээн томьёолсон байдаг.

Олон нийтийг сонсох. Энэ нь редакторуудын үйл ажиллагаатай холбоотой бөгөөд илүү дэлгэрэнгүй хариулт авахын тулд олон нийтийн дунд нээлттэй санал асуулга явуулах гэх мэт арга техникийг ашиглах үед хэрэглэдэг нэр томьёо юм. Энэ аргад нийгмийн амьдралын талаар мэргэжлийн бус энгийн мэдээлэл авах, иргэдийн санаа бодлыг тандаж мэдэхийн тулд тэднийг нэгтгэн хэлэлцүүлэг өрнүүлэх аргыг ч хамааруулж үздэг.

Олон нийтийн хурал, хэлэлцүүлэг. Сэтгүүлч санал асуух, багийн хэлэлцүүлэг өрнүүлэх, олон нийтийн санаа бодлыг сонсох замаар жирийн иргэдэд ямар асуудал байгааг тодорхойлох боломж олгодог арга юм. Үүнийг удирдах түвшний хүмүүс, улс төрийн шинжээч нарт хэт найдахаас сэргийлсэн илүү дөхөмтэй арга гэж үздэг.

Зөвлөгөөн, хэлэлцүүлэг. Олон нийтийн сэтгүүл зүй нь уламжлалт маргаан мэтгэлцээнийг мэдээлэхээс илүү шийдэлд хүрэх зорилготой хэлэлцүүлгийн аргыг түлхүү ашигладаг. Ийм хэлэлцүүлгийн үед сэтгүүлч эсрэг байр суурьтай хүмүүстэй ажиллаж байлаа ч гэсэн тууштай, зоригтой байж, хамт олноороо нэгдмэл ойлголтод хүрэхийг

чармайх ёстой бөгөөд бусдын буруу ойлголтыг нотлох гэж оролдох хэрэггүй юм.

Олон нийтийн харилцаа холбоо.

Хот суурингийн оршин суугчид олон нийтийн болон нийгмийн харилцааг мэдэхийн тулд сонин сэтгүүл зэрэг мэдээллийн хэрэгслийг ашиглах талаар зах хязгаарын хүмүүсээс давуу нөхцөл эдэлдэг. Тэд бас тулгамдсан асуудлын талаар санал хүсэлтээ илэрхийлж, хоорондоо зөвлөлдөж, сонин сэтгүүлд ханддаг.

Бүтэц. Сэтгүүлчид түүхийг бүтээхэд шинэ, хөгжингүй арга хэрэгтэй. Уламжлалаас үзэхэд сэтгүүлчид маргаж зөрөлдөх, нэг талыг барих, хэрэгцээгүй, тэр тусмаа эсрэг талын байр суурьд анхаарлаа хэт хандуулах зэрэг сул тал байсаар ирсэн. Харин өнөө үед асуудалд илүү хариуцлагатай хандаж, олон нийтэд аюултай байж болох асуудлын талаар мэдээлэх нь чухал болж байна. Их сургуулийн салбаруудын харилцан хамаарал нь зөвхөн сэтгүүл зүйн сургалтад хамаатай биш юм. Энэ харилцаанд “зөвлөх” гэдэг ойлголтыг авч үздэг. Зөвлөх гэдэг нь олон нийттэй холбогдсоны үр дүнг мэдээлэх аргад сургах тусламжийн үйл явц юм. Зөвлөгч нь магистр, мөн докторын зэрэгтэй байх бөгөөд мэдээллийн хэлтсийн бизнесийн сэтгүүлчдэд ирээдүйн төлөв байдал болон олон нийттэй холбогдох боломж олгоход тусалдаг.

Энэ чиглэлээр ихээхэн амжилт олж байгаа субъект бол Бетесда, Мериланд нарын үндэслэсэн Харвүүдийн бүлэг юм. Энэ бүлгийн гол үүрэг нь сэтгүүлчид хэрхэн ажиллаж байгааг үнэлж дүгнэх явдал аж. Бүлгийн нэг ахлагч Ричард Харвүүд нь фирмийн Ерөнхийлөгч бөгөөд, тэрээр хааяа болдог чуулга уулзалтын үеэр сэтгүүлчидтэй уулзаж хэвшжээ. Тэрээр мэдээллийн

хэлтсийн удирдлагын багийнхан сэтгүүлд санаа бодлоо илэрхийлэх, мөн сэтгүүлчдэд тавигдах шаардлагын талаар ярилцдаг байна. Р.Харвүүд түүхийн мөн чанар, уншигчидтай холбогдох эрмэлзэл, шинэ рефлексийн анхны хэлбэрийг сэргээж, дэс дарааллыг баталж, бусдад өндөр үнэлэгдэхүйц жинхэнэ сэтгүүл зүйг бий болгох арга замыг эрэлхийлдэг.

Харвүүдийн бүлэг болон бусад зөвлөлүүд нь мэргэшсэн сэтгүүлчдэд зориулсан үг хэллэг, нэр томъёог боловсруулахдаа олон нийтийн харилцааны их сургуулиудтай хамтарч ажилладаг. Тэд хуульчид, албан бус давхарга болох өмгөөлөгчид, гуравдагч давхарга буюу үсчний газар, хүүхэд хамгааллын төв, дагалдах давхарга буюу дэлгүүр, байшингийн арын хашаа, айл гэр хэмээх анхдагч давхаргыг хүртэл хамардаг бөгөөд, тус бүрд нь гүн гүнзгий утгатай тайлбарыг өгч чаддаг байна. Тэд иргэдийн амьдралын хураангуйлсан есөн нэр томъёог ашигладаг. Тэр нь *холболт, ерөнхий бичвэр, уялдаа, харилцааны салбар, сэтгэл хөдлөл, үнэн бодит байдал, боломжит үйл явц, хариуцлага, өөрчлөгч* зэрэг болно. Эдгээрийн утгыг ойлгосноор сэтгүүлчид хүчирхэг түүхийг бүтээж чадах аж. Жишээ нь сэтгүүлчид бичвэрийнхээ гол санааг ойлгож, чухал хүмүүстэй харилцаа тогтоохын зэрэгцээ, тэдгээрийн дотоод зөрчлийг хурцатгахгүй байх, мөн хүмүүстэй холбогдож тэдний хооронд олон төрлийн харилцаа үүсгэхийг эрмэлздэг.

Улирал тутам хэвлэгддэг профессоруудын мэдээ, мэдээллийн товхимлуудад урт сунжирсан үг хэллэг хэрэглэхийг цаг ямагт хориглодог. Ийм товхимлуудыг судлаачид, зохиогчид, магадгүй мэдээллийн хэлтэст загвар

болгон хэрэглэж болох юм. Профессоруудын эрэл хайгуулын үр дүн нь академик институциудийн хамгаалалд байдаг.

Жил бүр зохиогддог “АЕJMC” буюу Сэтгүүл зүй, олон нийтийн боловсролын ассоциацийн үеэр жинхэнэ оюун санааны уралдаан болдог. Өнгөрсөн жилүүдэд энэ ассоциаци «Шинэ түүхийг бүтээхэд дахин хэмжилт хийх аргын тогтолцоо», «Төлөөлөгчийн мэссэж ба баяр ёслолын үнэлэмж дэх эх сурвалжийн харилцан холбоо», «Бодит байдал ба танин мэдэхүйн онол», «Ярилцлага, лекц дэх шинэ байр суурь», «Сонин, сэтгүүл ба зөвхөн сэтгүүл уншигчдын ялгаа», «Мэдээллийн үнэн бодит байдлыг шүүмжлэхэд эх сурвалжийг ашиглах нь», «Олон нийтийн мэдээллийг хэвлэхэд редакторын судалгааны үүрэг» гэх мэт асуудлыг хэлэлцсэн байна.

Ассоциацийн чуулганы үр дүнд сэтгүүл зүйн профессорууд хийгээд олон нийтийн сэтгүүл зүйн зүтгэлтнүүд сэтгэл дундуур үлддэг. Учир нь тэдгээрийн тавьсан илтгэл болон шинэ санаануудыг мэдээллийн салбарт төдийлөн ашигладаггүй аж. Жишээлбэл Вашингтонд болсон сэтгүүл зүй ба олон нийтийн боловсролын ассоциацийн үеэр Рожер Мадд мэдээллийн үйлдвэрлэлд гүнзгий судалгаатай хандах тухай маш чухал асуудал хөндсөн боловч түүнийг хэн ч хэрэгжүүлээгүй байна. Тэдний үнэ цэнтэй илтгэлийг чуулганд оролцогчдод хувилж тараах төдийгөөр өнгөрчээ.

Канзас-Ситид болсон чуулган дээр Үндэсний Сонины Холбоо (NNA)-ны гүйцэтгэх ажилтан Тонда Раш Сэтгүүл зүй ба олон нийтийн боловсролын ассоциацийн үйл ажиллагаанд академик сэтгүүл зүй нөлөөлдөг байх ёстой гэсэн нь түгшүүрийн дохио болжээ. Тэрээр мэдээг олон нийтэд хүргэхдээ ихээхэн тэвчээртэй хандаж, нарийвчилсан судалгаа хийж, философийн томъёолол ба бодит байдлыг ил тод, дэс дараатай, ойлгомжтой дүрслэн харуулахад онцгой анхаарахыг сануулав. Раш оюутнуудад мэдээг шударга, тэнцвэртэй, агуулга хэлбэрийн нэгдэлтэй заахад сэтгүүл зүйн профессорууд анхаарах ёстой бөгөөд уламжлалт түүх, сургамжийн нууцыг нээхэд их цаг зарцуулах хэрэгтэй гэжээ. Ингэснээр хэвлэл мэдээллийн газруудад сэтгүүл зүйн сургуулийн төгсөгчдийн хүлээлт буй болно гэж тэрээр үзэж байна. Мөн дэлхий дахин мэдээллийн салбарт хэрхэн ажилладаг хийгээд зарим нэг санааг компьютер дээр хэрхэн хувиргах, утасны номон дээрх кодыг яаж тайлах зэрэг хөнгөн асуултуудад ч хариулах шаардлагатай аж.

Түүнчилэн сэтгүүл зүйн сургууль төгсөгчид Уотергейтийн тухай ямар нэг асуудлыг мэдэж байх ёстой гэж Раш хэлсэн. Тэрээр бас АЕJMC-ийн салбар, хэлтсийнхэн, их сургуулийн багш хоёрыг холдуулахаас зайлсхийж байгаагаа давтан хэлээд «Хэвлэлийн ажилтан, нийтлэгчид төрийн бодлогыг олон түмэнд яаж хүргэх тухай онолыг

«

Ассоциацийн чуулганы үр дүнд сэтгүүл зүйн профессорууд хийгээд олон нийтийн сэтгүүл зүйн зүтгэлтнүүд сэтгэл дундуур үлддэг. Учир нь тэдгээрийн тавьсан илтгэл болон шинэ санаануудыг мэдээллийн салбарт төдийлөн ашигладаггүй аж

»

боловсруулж, редакторууд улс төрийн бодлого шийдвэрийг хүүхэд ч ойлгохуйц хялбар болгон засч олон нийтэд хүргэсний үр дүнд сонгогчид саналаа өгдөг. Сэтгүүл зүй бол практик, бодит байдлыг чухалчилдаг бөгөөд ой мод өсч үржихтэй адил нийгэм оршин тогтноход чухал ач холбогдолтой ба эцэст хэлэхэд сэтгүүл зүй бол хэн нэгний эрхэлдэг гар урлал биш, шашин, улс төр, бизнес ч биш учир тэднээс ангид байгаасай гэж би хүсдэг»⁵ гэсэн байна.

Сан-Францискогийн Их сургуулийн Сэтгүүл зүйн тэнхимийн эрхлэгч Бетти Мэдсгэр «Вашингтон Пост» сонинд нэгэн өгүүлэл бичсэн нь Рашийн сэтгэлийг зовоосон асуудлыг дахин хөндсөн хэрэг болжээ. Тэрээр сэтгүүл зүйн боловсрол олгоход тулгамдаж байгаа зарим асуудлыг хөндсөн юм. Мэдсгэрийн санхүүжүүлсэн «Эрх чөлөө» хэмээх хэлэлцүүлгийн төсөлд олон эрдэмтэн багш оролцож Мэдсгэрийн бичсэн тайланг авч хэлэлцээд сэтгүүл зүйн сургуулийн сургалтын хөтөлбөрт ахиц гаргахуйц томоохон өөрчлөлтүүдийг санал болгосон бөгөөд дахин ул суурьтай нягтлах ёстой гэж тэд үзэцгээсэн байна. Мэдсгэр Их сургуулийн профессор багш нарын мэргэжлийн туршлага дутмаг байгаагаас оюутнуудад тайлагнах, бичих, хянан найруулах ур чадвар суулгах талаар учир дутагдалтай байна гэсэн дүгнэлтэд хүрчээ. Тэрээр энэ дүгнэлтэндээ тулгуурлан онол дадлага хосолсон маш сайн сургалтын хөтөлбөрийн үндсийг тавьсан юм.

Профессоруудын олонх нь олон нийтийн харилцааны онолын асуудлыг заахад илүүтэй анхаарч байсан бөгөөд сэтгүүл зүй ба олон нийтийн харилцааны практик туршлагыг боловсруулахад ихээхэн цаг хугацаа хэрэгтэй гэж

үзсэн байна. Мэдсгэр сэтгүүл зүйн сургалтын маш олон хөтөлбөрийг судалж үзсэний үндсэн дээр олонхид нь хөтөлбөрийн үүрэг, зорилгыг оновчтой тодорхойлж чадаагүй байсныг ажиглажээ. Тэрээр бас сэтгүүл зүйн магистрын хөтөлбөрүүдийн олонх нь бодит байдалд нийцэхгүй байна гэж дүгнээд бүтцийн өөрчлөлт хийх, эсвэл бүрмөсөн устгах хэрэгтэй гэж үзсэн байна. Мэдсгэр судалгаандаа сэтгүүл зүйн сургуулийн олон багш, судлаачид, мэдээний мэргэжилтнүүдийн “дуу хоолой”-г тусгаж, сэтгүүл зүйн боловсролын байдал, тэдгээрийн бодгал шинжийн ялгаанд үнэлэлт өгч, зарим саналыг судалгаандаа онцлон оруулжээ.

Висконсоны «Newslink» сонины үйл ажиллагаа хариуцсан эрхлэгч Эрик Мэйер болон сэтгүүл зүйн олон факультет Мэдсгэрийн практик судалгааны ач холбогдлыг өндөр үнэлсэн байна. Эрик Мэйер бол сэтгүүл зүйн боловсролд практик сургалтыг хэрхэн нэвтрүүлэх асуудлаар докторын зэрэг хамгаалсан онолч эрдэмтэн юм. Тэрээр мэргэжлийн их туршлагаа өвлүүлэх зорилгоор ШУА-ийн бараг бүх коллежийн багш нарыг дэмжиж ажилладаг. Мэйер, Мэдсгэр нар хэвлэлд өгсөн ярилцлагадаа «Сэтгүүл зүйн мэргэжлийн багш нэртэй хүмүүс олон байна. Гэхдээ тэд сэтгүүл зүйн сургуулийг бизнес болгож, төгсөгчдийг яаж сайн редактор, сэтгүүлч болгохын төлөө ажиллахгүй, огт санаа тавихгүй байна»⁶ гээд түүний учир шалтгааныг заахдаа сургалтанд туршлагатай сэтгүүлчдийг оролцуулдаггүй, оюутнуудад тэтгэлэг олгодоггүй, маш өндөр төлбөр авдаг гэжээ. Сэтгүүл зүйн сургуулийн үүрэг бол оюутнуудыг боловсролтой, арга туршлагатай сэтгүүлчид болгох явдал мөн гэж тэд үзжээ.

Хэвлэлийн Эрх Чөлөөний Хорооны ажилтан Жэйн Е. Киртлэй нэгэнтээ Мэдсгэрийн судалгаанд тайлбар хийхдээ «Сэтгүүл зүй бол нийгмийн шинжлэх ухаан биш, нийгмийн шинжлэх ухааны загварууд ч түүнд байхгүй. Мэдээний бизнес хийдэг тэдгээр хүмүүс их сургуулийн сэтгүүл зүйн боловсролд өөрчлөлт шинэчлэл хийхэд бүгд оролцох ёстой. Энэ ажилд ШУА-ийн оролцоо бас хэрэгтэй. Мэдээний ажилтнууд идэвхтэй, онол практикт тэгш суралцсан байх ёстой. Үүнийг л сэтгүүл зүйн боловсрол гэж нэрлэдэг»⁷ гэсэн байна. Тэрээр бас мэдээллийн редакци ажлаа практикаар илүү их тордвол цөөн тооны төгс мэдлэгтэй сэтгүүлч болон сэтгүүлчдийн байгууллагатай болох бололцоотой бөгөөд нийгмийн шинжлэх ухаан, шашны номлол зэргийг бодвол илүү нарийн, ур чадвартай сэтгүүл зүйг бий болгож чадна. Ингэснээр сэтгүүл зүйн оюутнуудад ярих урлаг эзэмшүүлж, олон нийтийн санаа бодлыг тандаж мэдэх чадвартай болгоно. Тэгээд зогсохгүй “Олон нийтийн сэтгүүл зүй” хэмээх шинэ хөдөлгөөнийг бий болгож, тэд тодорхой шийдвэр гаргаж, “олон нийт”, “иргэдийн өмнөөс” хэлэлцүүлэг, маргаан мэтгэлцээн өрнүүлэх чадвар эзэмшиж, жинхэнэ ардчиллыг сэргээх үйлсийн эхлэл болно гэж үзэж байна.

Америкийн 150 гаруй их, дээд сургуулийн багш нар болон сэтгүүлчдийн байгууллага нэгдэж «Олон нийтийн сэтгүүл зүйг сонирхогчдын бүлгэм» байгуулжээ. Анхных нь Миссурийн Их сургуулийн профессор Эдмонд Ламбертийн байгуулсан бүлгэм бөгөөд, түүнийг хамгийн хурдан өсч буй сонирхогчдын бүлэг гэж АЕJMC-ийн чуулган дүгнэсэн юм. Бүлгэмийн гишүүд олон нийтийн сэтгүүл зүйн тэтгэлгийн тухай

хэлэлцэж, сэтгүүл зүйн энэ чиглэлийн сургалтын шинэ агуулга, арга зүйг танилцуулж, аливаа байгууллага, албан тушаалтнаас ангид, зөвхөн олон нийтийн эрх ашгийн төлөөх сэтгүүл зүйг нийгэмд авчрахад чиглэсэн олон асуудлыг шийдвэрлэхийн тулд нийтээрээ тэмцсэн байна. Энэ нь гайхах зүйл биш ч гэсэн академик сэтгүүл зүйн маш олон ажилтан, сэтгүүл зүйн профессор багш нарт түгшүүрийн дохио болсон юм.

Олон нийтийн сэтгүүл зүй нь оюун санааны өнгөлгөөтэй, нийгмийн гоёл чимэглэл, хэл болоод мэргэжлийн академик сэтгэлгээтэй, төрөлхийн сонирхол татахуйц байх ёстой гэж бүлгэмийн гишүүд үзсэн байна. Тэд мэдээний бизнес нь орлого олохоосоо илүү олон нийтийг хамарсан, энэрэнгүй, чих тавьсан, зээл олгох боломжийг эрэлхийлсэн байх ёстой гэж үзсэн учраас академийн мэдээний ажилтнуудыг түгшээсэн юм. Үүнийг мэдэрсэн академийнхан тэтгэлэгт цааргалдаг байдал, онол давамгайлсан заах аргаа өөрчилснөөс хойш тэднийг буруутгах хүн гарахаа больжээ. Тэд олон нийтийн сэтгүүл зүйн шүүмжлэлийг хүлээн авч, уламжлалт сэтгүүл зүй, түүний сургалтын хөтөлбөрийг өөрчлөн шинэчилж, олон шинэ санаануудаар баяжуулсан байна.

Сент-Луисийн Их сургуулийн профессор, олон нийтийн сэтгүүл зүйг сурталчлагч Жон Раул олон нийтийн сэтгүүл зүй нь уламжлалт сэтгүүл зүйгээс сургамж авч тусгаарлаад 15 жил болж байгааг тэмдэглээд «Ерээд онд сэтгүүл зүйд гарсан хөдөлгөөнийг олон нийтийн сэтгүүл зүй төлөөлж чадна. Уламжлалт болон олон нийтийн сэтгүүл зүйн аль аль нь мэдээний хэрэглэгч болох уншигч, сонсогч, үзэгчдэд баримжаатай, зөрчилгүй, үнэн

бодит мэдээллийг хүргэх нэгэн зорилготой. Сэтгүүл зүйн бүтээл нь ард олон, уншигчдын эдийн засгийн хүндрэл бэрхшээлийг багасгах, иргэдийн амьдралын орчин нөхцлийг сайжруулахад чиглэж байх ёстой. Олон нийтийн сэтгүүл зүй нь нийгмийн түүхэн дэх чухал үе шат биш, зөвхөн сонины түүхэн дэх чухал мөчлөг юм»⁸ гэж хэлсэн байдаг.

Олон нийтийн сэтгүүл зүй нь судалгааны үндсэн дээр мэдээллийг эх сурвалжаас нь авдаг, улс орон даяар сонины борлуулалт буурах үед үндэстнийг шоглож хошигносон мэдээ нийтлэх зэргээр олон нийтийн анхаарлыг татах аргатай байдаг. Энэ шинэ чиглэлийг сэтгүүл зүйн сор гэж үзэх явдал байдаг нь олон нийтийн туршлагатай сэтгүүлчийн нийтэлсэн мэдээ материал нь хэн нэгнээс хамаардаггүй, тэр чанараараа сэтгүүл зүйд ахиц дэвшил авчирсантай холбоотой юм. Уламжлалт сэтгүүлчдийг муулах, тэдний санааг гоочилж шүүмжлэх, буруу ташаа ойлгохыг олон нийтийн сэтгүүл зүй тэвчдэггүй. Түүнээс гадна олон нийтийн сэтгүүл зүй нь бодит байдалд тулгуурлан гарч ирсэн. Уламжлалт сэтгүүл зүйд байдаг хуучинсаг үзэл, унхиагүй байдал, хэн нэгний захиалгаар ажиллах явдлаас олон нийтийн сэтгүүл зүй сэрэмжлүүлж чаддаг. Ийм зүйл болсон даруйд мэдээллийн хэлтэс болон сурвалжлагчид семинар, чуулган зохион байгуулж, олон нийтийн сэтгүүл зүйн зөвлөлийн шийдвэрийг дагадаг. Мөн сэтгүүл зүйн их сургуулийн багш нар, сургалтын албаныхан авч хэлэлцээд эрдэмтдээс олон нийтийн сэтгүүл зүйд оруулсан саналыг дэмжиж, хамгаалдаг байна.

Сэтгүүл зүйн профессор Дэвис Буз Мэррит жил бүр зохиогддог АЕJMC-ийн

чуулганд тогтмол оролцдог эрдэмтэн юм. Тэрээр оюутнуудад үзэгчээ хэрхэн мэдэрч өөртөө татах талаар зөвлөдөг. Тухайлбал оюутнуудаас яагаад заавал сэтгүүлч мэргэжлийг сонгосныг асуухад тэдний дийлэнх нь «Би зорилготой байхыг хүсдэг», «Би шударга байхыг илүүд үздэг» гэсэн бол нөгөө хэсэг нь “ярих”, “бичих”, “өөрчлөлт хийх”-ийг хүсдэг гэж хариулсан байна. Эдгээр хариулт нь оюутнууд мэргэжилдээ тийм ч дуртай биш байгааг харуулжээ. Хүмүүс хэтэрхий шударга, үнэнч занд дургүй учраас сэтгүүлчийн мэргэжилд татагддаггүй байна.

Мэрритийн үзэж байгаагаар залуу хүмүүс сэтгүүл зүйд орсноор өөрийн үзэл бодлоо илэрхийлж болдоггүй учир тэд ихэнх цагаа уламжлалт сэтгүүл зүйн хичээлд сууж өнгөрүүлдэг байна. Энэ нь оюутнуудад шударга, тэнцвэртэй, зорилготой байх гэх мэт олон талын эерэг нөлөө үзүүлдэг аж. Жей Розенгийн уриалгаар профессор Жим Карей төгсөх ангийн оюутнуудтай ярилцсан тухай Мэррит дурдсан юм. Жим Карей эхний жилд 16 долоо хоног буюу бүтэн семестр хичээл заасны дараа оюутнуудын 90 хувь нь мэргэжилдээ эргэлзэж эхэлжээ. Дараа жилд Карейн урилгаар Розен хоёр долоо хоног хичээл заахад оюутнууд «Тийм ээ, яагаад гэвэл бид сэтгүүлч болохын тулд энд байгаа» гэж хариулсан байна. Мэрритийн дүгнэлтээр Розений барил нь оюутнуудыг сэтгүүл зүйд оруулах хамгийн хялбар арга байжээ.

Мэррит болон Олон нийтийн сэтгүүл зүйн зөвлөл сэтгүүл зүйн уламжлалт үнэ цэнг хадгалахын тулд оюутнуудыг элсүүлэхийг хүсдэг. «Earlham» коллежийн багш Чэрил Гиббс-д сэтгүүл зүйн сургуулийг удирдаж, олон нийтийн сэтгүүл зүйг заах санал тавьсан бөгөөд

түүний хичээл зүтгэлээр анхны олон нийтийн сэтгүүл зүйн анги нээгдсэн байна. Гиббсийн заах арга барил чадварлаг, оюутнуудтайгаа харилцан ярилцаж, тэдэнд тусалж дэмжих зэргээр ойр дотно байж, санал гомдлыг нь сонсдог зэрэг нь оюутнуудыг татах хөшүүрэг болжээ. Тэрээр зарим үед оюутнуудаар орон нутгийн сонин уншуулж, төгсгөлийг нь тэднээр бичүүлж, хооронд нь харьцуулан хэлэлцдэг. Гиббс бусдаас их дуурайлал авдаг онцлогтой. Тухайлбал Энэтхэгийн Их сургуулийн багш Дэви Боейкийн оюутнуудаас шалгалт авах таван аргыг ашигласан байдаг. Тэрээр ангийг багт хуваарилж, баг тус бүрт таван философийг ойлгуулж, боловсруулж, мэдээллийг баяжуулдаг байв. Үүний давуу тал нь иргэний сэтгүүл зүй болон олон нийтийн сэтгүүл зүйн зааг ялгааг гаргадаг сайн талтай аж. Гиббс профессор Жаки Фарнан, Рошестер нар болон коллежийн багш Жон Фишерийн олон нийтийн сэтгүүл зүйн сургалтын арга барил, технологиос үргэлж суралцаж үлгэр жишээ авдаг байв.

Фарнан оюутнуудынхаа ангийн ажлыг илүү өргөн хүрээнд хийлгэдэг. Тэр хэлэхдээ «Хамгийн том сорилт бол сурвалжлагын шинэ арга барилыг судалж олох явдал мөн» гэжээ. Мөн сэтгүүл зүйн ангийн оюутнууд сурвалжлагын арга хэлбэрийг тодорхойлж, асуултыг оновчтой тавьдаг байх хэрэгтэй. Тийм учраас мэргэжлийн мянга мянган сэтгүүлч олон нийтийн сэтгүүл зүйд багтдаг. Сэтгүүл зүйн мэргэжлийн оюутнуудыг уламжлалт сэтгүүл зүйд оруулахын тулд мэдээ эрхлэгчид илүү их өөрчлөлт хийх хэрэгтэй. Мөн олон нийтийн сэтгүүл зүйд шинээр орж ирсэн үг хэллэг, нэр томъёог мэддэг байх,

сэтгүүлч сурвалжлагч нар иргэдийн хүсэлтэд туслах аргыг зөв шийдэх чадвартай байх ёстой. Сэтгүүлч болох оюутнуудаар богинохон сурвалжлага хийлгэх нь тэдэнд туршлага болж өгдөг. Тэр нь хүмүүс олон зүйлийн тухай харилцан ярилцсан энгийн яриа байх юм.

Орчин үеийн олон нийтийн сэтгүүл зүйн багш нар мэдээний эрхлэгчийн зөвшөөрөлгүйгээр хуурамч мэдээллийг олон нийтэд түгээх, нийтлэхийг хориглон анхааруулдаг байх учиртай. Бид урьд нь ямар мэдээлэл олсон бол түүнийгээ л нийтэлдэг байсан. Тэр цагаас хойш олон нийтийн чиг хандлага ерөнхийдөө сонссон зүйлдээ л итгэдэг болсон. Тиймээс мэдээлэл үнэн бодитой, баттай эх сурвалжтай байх ёстой. Тухайлбал сэтгүүл зүйн салбарын сурган хүмүүжүүлэгч нар оюутнууд нь олон нийтийн сэтгүүл зүйд хамаарах төрөл бүрийн мэдээ, мэдээлэл авч ирэхэд тэдгээрийг авч хэлэлцэн, хэрхэн мэдээ болгох талаар зааж зөвлөдөг. Мэргэжлийн байгууллагаас бэлтгэн гаргасан цуврал номонд мэдээллийн сэтгүүл зүй ба олон нийтийн сэтгүүл зүй гэсэн ангилал гаргаж өгсөн нь их сургуулийн оюутнууд ойлгоход дөхөм болжээ.

Сөрөг хүчнийхэн Сэтгүүл зүйн академийг олон нийтийн сэтгүүл зүй хийх гол хүч гэж дүгнэжээ. Энэ нь *Нэгдүгээрт*: мэдээ хийх уламжлалт арга хоцрогдсон гэдэгт олон нийтийн сэтгүүлчид хараахан итгэж өгөхгүй байсан. Хамгийн шилдэг олон нийтийн сэтгүүл зүй нь ердөө л уламжлалт сэтгүүл зүйн сайн арга туршлага дээр суурилсан байдаг. Гэтэл хамгийн муу олон нийтийн сэтгүүл зүй нь хараат бус байдал, үнэн бодитой байх зэргийг хайхрахгүй байгаа нь үнэндээ уламжлалт сэтгүүл зүйн санал болгодог

бүтээлч сэтгэхүйг зөрчиж байгаа хэрэг юм. *Хоёрдугаарт*: олон нийтийн сэтгүүл зүйн мэдээний тухай ойлголт нь сэтгүүл зүйд баримталдаг сурах бичигтэй зарим талаараа зөрчилддөг. Алдарт Миссури групп эх бичвэрийн зөрчлийг чухалчлан үзэж, шинэ содон байдал, сонирхолтой болон чухал ач холбогдолтой байх зэрэг нь мэдээний шалгуур болдог гэж үздэг. Олон нийтийн сэтгүүл зүйн шүүмжлэлд өртдөг хэсэг нь уламжлалт мэдээний аргыг ашигладаг оршдог.

Сэтгүүл зүйн сургуулиуд нь уламжлалт болон олон нийтийн сэтгүүл зүйн чиг хандлагыг нэгэн адил заадаг боловч үнэн хэрэгтээ төгсөгчид нь академид дүүргэсэн хойно бодит байдал дээр мэдээг хэрхэн бэлтгэх, юуг мэдээ болгож болох тухайд ихээхэн будилдаг байна.

Гуравдугаарт: сэтгүүл зүйн боловсролын үндсэн үүрэг нь суралцагчдад ил тод, товч хураангуй илтгэж сурахыг л заах явдал мөн. Энэ тухайд «Тодорхой байх, тодорхой байх, тодорхой байх!» гэдэг зарчим баримталдаг. Нийтлэлийн утга зохиолын бичвэр нь яг л аянгын дуу шиг байх хэрэгтэй. Хэзээ нэгэн цагт номын хуудас салбарч муудсан ч доторх бичвэр нь бүгдэд ойлгомжтой байх ёстой. Бид хэн нэгэн залуу сэтгүүлчийн бичлэгээс “иргэний орон зай”, “яриа хэлэлцүүлэг”-ийн идэвхтэй, шинэлэг аргыг хүлээж байдаг. Ингэж чаддаг сэтгүүлч нь олон нийтийн өмнө давтагдсаар улиг болсон нийтлэлийн хуучин арга хэлбэрийг сонирхолтой, шинэлэг болгоход туслах болно. Хамгийн чухал нь сэтгүүлчийг уншигчийн юу хүсч байгааг мэдэрч ойлгоод, тэдэнтэй холбогдож чаддаг

болгоход л олон нийтийн сэтгүүл зүйн сургалт чиглэх ёстой болж байна.

Ишлэл

- ¹ *Esther Thorson*. 1996. *Civic Lessons*. Madison, p. 21.
- ² *Норовсүрэн Л., Энхтүяа Х.* 2005. Иргэний сэтгүүл зүй. УБ., 4 дэх тал.
- ³ 1998. *Don't Stop There! Five Adventures in Civic Journalism*. Washington, p. 7.
- ⁴ *Don H. Corrigan*. 1999. *The Public Journalism Movement in America*. London, p. 145.
- ⁵ Дурд. зох., p. 149
- ⁶ Мөн тэнд.
- ⁷ Дурд. зох., p. 150.
- ⁸ Дурд. зох., p. 151.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. 1998. *Don't Stop There! Five Adventures in Civic Journalism*. Washington.
2. *Don H. Corrigan*. 1999. *The Public Journalism Movement in America*. London.
3. *Esther Thorson*. 1996. *Civic Lessons*. Madison.
4. *Зулькафиль М.* 1999. Сэтгүүл зүйн онолын үндэс. (Тэргүүн дэвтэр). УБ.
5. *Норовсүрэн Л., Энхтүяа Х.* 2005. Иргэний сэтгүүл зүй. УБ.
6. *Норовсүрэн Л.* 2003. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. (Гутгаар дэвтэр). УБ.

Резюме

В данной статье автор подробно рассматривает аспекты возникновения, развития и распространения массовой журналистики, в том числе особенности функционирования в Монголии. По мнению автора, для эффективного развития этого нового направления в журналистике необходимо формирование учебной системы. Автор выдвинул свои идеи о понятиях, специфике функционирования, нормах взаимоотношения с традиционной журналистикой, эффективных методах и формах развития массовой журналистики и др.